

“ТӨГРӨГ 100”- ТӨГРӨГ МИНИЙ ӨЧИЛ

Хөх тэнгэрийн доор төрсөн мөнгөн түүх минь
Хөвчин дэлхийн дунд мандсан эрх чөлөөний илэрхийлэл
Эгнэгт энэ нэрээрээ эгшиглэн үлдэх итгэл
Эцэг өвгөдийн сэтгэлийн сор, тусгаар тогтнолын бэлэгдэл
Гар дээр атгаатай атлаа зүрхэнд илүү ойр
Газар шорооны минь адис шингэсэн ариун төгрөг
Гуниг, баярын хос аястай хорвоод зам мөрөө гэрэлтүүлж үлдсэн
Зөвхөн ганцхан төгрөгийн цаасан биед Монголын зууны түүх, зовлон,
золжаргал багтжээ.

Зуун жил бол цаг тооллын эгшиг биш, үндэстний ухамсрын шугам. Энэ шугам дагуу Монголын ард түмэн өвгөдөөс өвлөсөн тусгаар тогтнолын сүнсийг мөнгөн тэмдэгт хэмээх хэлбэрт хувиргаж төрийн сүлдийг төгрөгт шингээсэн нь өнөөдөр бидний гарын алганд атгаатай буй.

Намайг Төгрөг гэдэг. 1925 оны 12 сарын 9-нд мэндэлсэн. Төрөхдөө мөнгөн зоосны биетэй, нүүрэн дээрээ Монгол бичгийн нэртэй байсан. Тухайн үед надаас илүү үнэ цэнтэй зүйл Монголд байгаагүй. Шинэ тусгаар тогтнолын анхны амьсгал нь байлаа. Би байдаг л энгийн цаас биш. Би амьд. Би нэг зууныг туулсан, хүмүүсийн гараар дамжиж, халаасанд орж, мөрөөдөлд хадгалагдаж, залуусын төлөвлөгөөнд тоологдож, ээж аавын хөлсийг шингээсэн. Олон мянган хүний амьдралын утга учир болон яваа гэрч нь. Гэвч тийм ч амар амгалан яваагүй. 1930-аад он, би цаасан дэвсгэрт болж, төлөвлөгөөт эдийн засгийн чимээгүй зүтгэгч боллоо. Тариачны гар дээрээс үйлдвэрчний гарт очиж, улмаар улсын тооцоонд шингэн орж байсан. 1990 он бол миний амьдралын хамгийн ширүүн салхи. Инфляц 300%-аас давж, ханш хормын төдийд уруудаж байсан. Тухайн үед 1 ам.доллар 40 төгрөг байснаа 1000 давж би үнэ цэнээ алдсан мэт санагдсан. Гэхдээ монголчууд намайг хэзээ ч хаяагүй. Тэр сорилт дундаас бид хамтдаа амьд гарсан. Заримдаа намайг гадаад валюттай харьцуулж, үнэ цэнгүй мэт хэлдэг. Би чинь зүгээр нэг мөнгө биш, Монгол өөрөө шүү дээ. Доллар хурдан байж мэднэ. Юань хүчтэй байж болно. Харин чи намайг хэрхэн хайрлаж байна вэ? Өнөөдөр би АТМ-д сууна. Онлайн банкны аппликэйшн дотор амьдарна. QR код уншуулах болгонд миний нэр дуудагдана. Би дэвсгэртээр л оршдоггүй. Хүний санах ойд,

төлөвлөгөөнд, хадгаламжийн дэвтэрт, зээлийн хүсэлт дээр гээд хаа сайгүй оршдог. Хаа сайгүй байгаа мөртлөө ганцхан Монголдоо л үнэ цэнтэй.

Та намайг алдахад харамсдаг, хадгалахад баярладаг. Та намайг цуглуулдаг хуваалцдаг, заримдаа мартдаг. Гэвч би таны амьдралд үргэлж байгаа. 10 төгрөг? 1000 төгрөг? 20000 төгрөг үү? Тоон дээр тулгуурлан надад хайр, зэвүү хоёрыг зэрэг үзүүлдэг хүний сэтгэлд би үнэндээ ямар үнэ цэнтэй вэ? Хэнтийн ууланд малчин хүний гар дээр ч байдаг, Харвардын оюутны түрийвчинд ч багтдаг. Би хаана ч хүрч чаддаг, гэхдээ хаа сайгүй урагдаж, нугларч, хиртэж, хүүхдийн будсан зураг болж, хогон дунд төөрч, хуурамч хувилбарынхаа сүүдэрт дарагдаж, “Хуучин мөнгө” хэмээгддэг. Өнөөдөр миний үнэ цэнэ зөвхөн ханшаар хэмжигдэхгүй. Харин таны хүнлэг сэтгэлээр л хэмжигдэнэ. Намайг хайрлахын тулд баян байх албагүй. Зөвхөн ухамсартай байхад л хангалттай.

“Хүүхдэдээ зөвхөн мөнгө тоолох биш, төгрөгийн үнэ цэнийг таних ухаан, зүрхнээсээ хүндлэх ухамсар өвлүүлээрэй.” Халаасандаа намайг бөөгнүүлж, цоолж, будагдахаас хамгаалаарай. Хуурамч хувилбар биш, итгэлийг чинь илэрхийлэгч жинхэнэ төгрөг байхад минь туслаарай.

Шинэ зууны босгон дээр ирээд, би чимээгүйхэн асууна. Монгол төгрөгийн хувь заяа хаашаа чиглэх вэ?. 2024 оны байдлаар Монгол Улсын гадаад өр 34.2 тэрбум ам.долларт хүрсэн нь ДНБ-ий 220 орчим хувийг эзэлж би түүний дарамтад даруулж эхэллээ. Валютын ханш тасралтгүй өсөж, импорт давамгайлсан. Тухайлбал, Монголбанкны 2021 оны эцсийн ханшийн мэдээллээр 1 ам.доллар 2850 төгрөг байсан бол 2024 оны 4-р сард 3520 төгрөгт хүрсэн нь 23%-ийн өсөлт юм. Эдийн засагт миний худалдан авах чадвар өнгөрсөн арван жилд үлэмж буурав. Үндэсний статистикийн хорооны 2024 оны 1-р улирлын мэдээллээр махны үнэ 2019 оноос хойш дунджаар 2.6 дахин, гурил 2.3 дахин, сүү 2.1 дахин нэмэгджээ. Хэрэглээний сагсны өртөг 2015 онд дунджаар 80,000 төгрөг байсан бол 2024 онд 210,000 орчим төгрөг болж өссөн байна. Үнийн энэ өсөлт махны үнэ нэмэгдсэнээс бус, миний үнэ цэнийг бид дотроосоо бууруулж байгаатай холбоотой. Инфляци бидний эдийн засгийн тогтворгүй байдлыг илчилж байна. Гэтэл Монголын хэрэглээний бараа бүтээгдэхүүний 80 орчим хувь нь гадаадаас хамааралтай учир валютын ханш савлах бүрт дотоодын үйлдвэрлэл үнийг “дарж” чадахгүй байна. “Ковидын

дараа эдийн засгийг дэмжих зорилгоор төрөөс зээлийн хүүг бууруулж, их хэмжээний төгрөгийг зах зээлд нийлүүлжээ. Үүний улмаас эрэлт нэмэгдэж, нийлүүлэлт хүрэлцээгүй болсон нь инфляцийн галыг улам дүрэлзүүлсэн юм.” Гэхдээ энэ бүхнийг зөвхөн гадаад хүчин зүйлсээр тайлбарлаж болохгүй. Инфляци бол гадаад ертөнцийн “дайралт” биш бидний дотоод бодлого, зан төлөв, ойлголт дутмаг байдлын үр дүн юм.

Би зүгээр алга болохыг хүсэхгүй тул шинэчлэгдэхэд бэлэн. Жил бүр Монголбанк 30–40 тонн дэвсгэртийг устгадаг. Ухаалаг, урт настай, эко мөнгөн тэмдэгт болохыг хүсэж байна. Жишээлбэл, Канад, Австрали улс полимер материалтай мөнгөн дэвсгэрт хэрэглэж, байгаль орчноо хамгаалж, мөнгөө илүү удаан хугацаанд эргэлтэд байлгаж чадсан. Дэлхийн жишгийг дагаж санаачилгыг нэвтрүүлж, байгальд ээлтэй, удаан хэрэглэгдэх шинэ төрлийн мөнгөн тэмдэгт болох цаг иржээ.

Үнэ цэнийг минь хадгалах, өсгөх хамгийн бат бөх суурь бол үндэсний үйлдвэрлэл. Импортын хамаарлыг багасгах хамгийн шууд арга бол “Монголдоо үйлдвэрлэж, Монголдоо хэрэглэдэг” орчин бүрдүүлэх. Гэхдээ зөвхөн төр, компаниуд гэлтгүй иргэн бүр оролцох ёстой. Хүн бүрийн оролцоо эдийн засгийн дархлааг бий болгоно.

Иргэн бүр дараах гурван зүйлд анхаарах хэрэгтэй 1.Санхүүгийн боловсролтой байх -орлогоо зөв зарцуулах, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулах мэдлэгтэй болох 2.Хувийн хариуцлагатай байх -татвараа үнэнч төлөх, зээлээ хугацаанд нь төлөх, залилангаас зайлсхийх ухамсартай байх 3. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих -дотоодын бараа, үйлчилгээг сонгож, үндэсний эдийн засгаа дэмжих. Аз болоход бидэнд итгэл төрүүлэх гурван боломж бий.

Нэгдүгээрт, цахим төлбөр тооцоо хурдацтай хөгжиж байна. Гар утсаараа худалдаа хийх, банкин дээр дугаарлахгүйгээр гүйлгээ хийх нь амьдралыг хөнгөвчлөөд зогсохгүй, эдийн засгийг ил тод, хяналттай болгох боломжийг бүрдүүлж байна.

Хоёрдугаарт, дотоодын технологи, залуусын стартапууд хүчтэй хөгжиж байна. Монголын хөгжлийн банкууд шинэ санаачилгыг дэмжин, үйлдвэрлэл, бүтээлч санааг бодит ажил болгон хувиргаж байна.

Гуравдугаарт, нар, салхи, усан цахилгаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Энэ нь байгальд хоргүй, тогтвортой, урт хугацаанд ашигтай эдийн засгийг бүрдүүлэх суурь болдог. Үүнийг “ногоон хөгжил” гэж нэрлэдэг. Сорилт олон байсан, сорьсон ч байна. Гэвч эдгээр бэрхшээл биднийг сөхрүүлж бус, сэрээж, урагш тэмүүлэх эрч хүч болдог.

Хуулийн дагуу намайг гэмтээхийг хориглодог. Миний зүрхэнд шингэсэн дурсамжийг уран сайхны богино бичлэг, reel-д буулган, Tik tok, YouTube, Facebook зэрэгт нийтлэн танин мэдэх, мэдлэгээрээ өрсөлдөж болно шүү. Би ингэж олон хүнд өөрийгөө ярьмаар байна. Өнгөрсөн 100 жилийн дэвсгэртүүдийг, дүр төрхөө нийтэд толилуулъя. Би янз бүрийн өнгө, дүрстэй, үе үеийн дүр төрхөөрөө амьдарч ирсэн. Миний хувьслыг харуулсан тэр зэсгэлэн бол зуун жилийн бахархлыг нэг дор үзэх боломж болох юм шүү.

Иргэн бүр санхүүгийн мэдлэгтэй, хариуцлагатай, үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг байж чадвал бид зөвхөн эдийн засгаа хамгаалаад зогсохгүй, ирээдүйн хөгжил, баялаг руу хамтдаа алхаж чадна. Энэ зуун бол уналтын бус, урагшлахын зуун байх болно. Монгол хүн бүр итгэлтэй, ухаалаг, эв нэгдэлтэй байх үед би үргэлж оршиж, үнэ цэнтэй байх болно. Би төгрөгөө хайрлана

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын

1 дүгээр сургуулийн 11в ангийн сурагч

Гантөмөрийн Номин-Эрдэнэ.